



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/Н


Улаанбаатар хот

Соёлын ордны төлбөрт үйлчилгээний
хураамж, түрээсийн төлбөрийн
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг тус тус үндэслэн нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Соёлын ордны төлбөрт үйлчилгээний хураамж, түрээсийн төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Тогтоол батлагдсан өдрөөс эхлэн төлбөрт үйлчилгээний хураамж, түрээсийн төлбөрийг шинэчлэн мөрдөж ажиллахыг дүүргийн Соёлын ордон/Б.Алтанцоож/-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 35 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Х.ЦОГЦЭЦЭГ

01123 0100027

Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 02 дугаар сарын
19 - ний өдрийн 111 дүгээр тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН СОЁЛЫН ОРДНЫ ТӨЛБӨРТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ, ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР

1. Дотооддоо

Д/д	Үйлчилгээний төрөл	хугацаа	Үйлчилгээний үнийн хураамж /төгрөг/		Тайлбар
			Хүүхэд	Том хүн	
1	Уран сайхны хамтлаг уран бүтээлчид, ардын авьяастнуудын тоглолт	1-1.30 цаг	2500	5000	
2	Дэлгэцийн болон дүрс бичлэгийн кино	2-2.30 цаг	1000-3000	3000-6000	
3	Нийтийн цэнгээнт бүжиг, диско бүжиг	2 цаг	1000	3000	
4	Бичлэг понаграмм хийлгэх	15000- 30000			
5	Хоолойны бичлэг хийлгэх	50000			
6	Каноны үйлчилгээ	1 хуудас	200		
7	Багш нарын уран бүтээлийн тоглолт /тайлан концерт/	2 цаг	2500	5000	

2. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд

Д/д	Үйлчилгээний төрөл	хугацаа	Үйлчилгээний үнийн хураамж /төгрөг/	Тайлбар
1	Зал, талбай, явуулын тайз, техник хэрэгсэл гэрээгээр түрээслүүлэх	1 цаг	500000	
2	Уулзалт хүлээн авалт, үзэсгэлэн худалдаа, хурал, цуглаан г.м бусад арга хэмжээ, үйлчилгээ	1 цаг	20000	
3	Хувцас, хөгжмийн прокат үйлчилгээ 1ш	1 өдөр	15000	
4	Багш нарын уран бүтээлийн тоглолт /тайлан концерт/	1 цаг	200000	
5	Морин хуур, уртын дууч, хөгжимчин, хөтлөгч, дуучид, бүжигчид	1-3 цаг	50000-400000	
6	Өөр орон нутаг бүсэд захиалгаар тоглолтын үйлчилгээ үзүүлэх	2 цаг	500000	
7	Дугуйлан сургалт	1 сар	15000-30000	
8	Гадны байгууллага, хувь хүн тоглолт хийх, үзвэрийн үйлчилгээ	1цаг	Орлогын 15-30 хувь	
9	Yamaha болон үндэсний хөгжмийн хөгжим түрээслүүлэх	1 өдөр	30000-50000	